



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/573

Эрдэнэт

Сургалтын зардал гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 а, 29.2, 33 дугаар зүйлийн 33.1.6, Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2017 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн төрийн албан хаагчдын 2017 оны сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулах төрийн албанд шинээр томилогдсон гүйцэтгэх ажилтнуудын “Төрийн албаны стандарт” сургалтын зардал 3600000 /Гурван сая зургаан зуу/, удирдах албан тушаалтнуудын сургалтын зардал 6400000 /Зургаан сая дөрвөн зуу/ төгрөгийг 2017 оны Засаг даргын нөөц сан, хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтад тусгагдсан төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлон, үе шаттайгаар сургаж мэргэшүүлэх, төрийн байгууллага бүрийг суралцагч байгууллага болгон хөгжүүлэх арга хэмжээний зардлаас тус тус гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

2.Сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /н.Соёлчхүү/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Д.БАТЛУТ